

МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 18.1, 18.7 дүгээр зүйл, Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2024 оны А/143 дүгээр тушаалын хавсралт “Оюутан элсүүлэх журам”, Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС)-ийн дүрэм болон тус “Элсэлтийн журам”-ыг баталсан сургуулийн Захирлын тушаалыг үндэслэл болгоно.

1. Үндэслэл

- 1.1. Энэхүү “Оюутан элсүүлэх журам” (цаашид “Журам” гэх) нь Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС)-ийн бүх сургалтын хөтөлбөрийн элсэлтийн үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. МГТИС-ийн захирал нь 1.1-д заасны дагуу Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журмын нийцүүлэн элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах Элсэлтийн комиссыг томилно. Тус сургууль нь Инженерийн бэлтгэл хөтөлбөр (ИБХ), Бакалавр болон Магистрын хөтөлбөрт элсэлт авна.
- 1.3. Элсэлтийн комиссын гишүүн бүр санал өгөх тэгш эрхтэй бөгөөд санал тэнцсэн тохиолдолд Комиссын дарга санал хураалтыг шийдвэрлэнэ.
- 1.4. Элсэлтийн комисс нь элсэгчдийн мэдлэг, ур чадварыг үнэн зөв, бодитой, шударгаар МГТИС-ийн үнэт зүйлд нийцүүлэн үнэлэх ба оюутан элсүүлэх шийдвэрийн ил тод байдлыг ханган ажиллана.
- 1.5. Элсэлтийн комисс нь элсэлттэй холбоотой бүхий л гомдол, хүсэлтийг шийдвэрлэнэ.
- 1.6. Элсэлтийн комисс нь элсэгчдийн ирүүлсэн баримт бичиг, ярилцлагын үр дүнд үндэслэн элсэгчдийг сонгон шалгаруулж, Захирлын зөвлөлөөр баталгаажуулахаар танилцуулна.

2. Элсэгчдэд тавих шаардлагууд

2.1. Бакалаврын хөтөлбөр болон Инженерийн бэлтгэл хөтөлбөрт элсэгчдэд

- 2.1.1. Элсэгч нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн байна.
- 2.1.2. МГТИС нь Элсэлтийн Ерөнхий Шалгалт (ЭЕШ)-ын оноонд үндэслэн элсэгчдэд хөтөлбөрт элсэх эсэх саналыг хүргүүлнэ.
- 2.1.3. Хөтөлбөрт элсэхийн тулд элсэгчийн хүчинтэй ЭЕШ-ын оноо нь дараах шаардлагыг хангасан байна.
 - Бакалаврын хөтөлбөрт элсэгч нь Математик, Физик эсвэл Химийн хичээлээр ЭЕШ-ын 600-аас доошгүй оноотой байх; (ЭЕШ-ын гүйцэтгэлийн оноонд үндэслэн босго оноог тохируулж болно)
 - ИБХ-т элсэгч нь Математикийн хичээлээр ЭЕШ-ын 520-аас доошгүй оноотой байх.
- 2.1.4. МГТИС нь 2.1.2-оос гадна нэмэлтээр 2.1.5-д заасан Байгалийн шинжлэх ухаан болон Англи хэлний нэмэлт элсэлтийн шалгалтын үндсэн дээр элсэх

- боломжийг санал болгоно. Энэхүү шалгалтыг ЭЕШ-ын өмнө зохион байгуулна.
- 2.1.5. Байгалийн шинжлэх ухаан болон Англи хэлний нэмэлт элсэлтийн шалгалтыг МГТИС-ээс зохион байгуулж болно. Шалгалтын үр дүнг хоёр долоо хоногийн дотор нийтэлнэ.
- Нэмэлт элсэлтийн шалгалт нь Математик, Физик болон Химийн хичээлүүдээс бүрдэх ба тэдгээрийн нийт оноог үнэлнэ;
 - Бакалаврын хөтөлбөрт элсэхэд гүйцэтгэлийн нийт оноо 60% ба түүнээс дээш байх шаардлагатай;
 - ИБХ-т элсэхэд гүйцэтгэлийн нийт оноо 40% ба түүнээс дээш байх шаардлагатай.
 - Бакалаврын хөтөлбөрт элсэхэд Англи хэлний В2 түвшин (ахисан дунд) шаардлагатай; (МГТИС-ийн “Сургалт, шалгалтын ерөнхий журам”-ын дагуу бакалаврын хөтөлбөрт суралцахын тулд хичээлийн 1-р семестр дуусахад оюутан нь Англи хэлний С1 түвшинд хүрсэн байх ёстой.)
 - ИБХ-т элсэхэд В1 түвшин (дунд) байх шаардлагатай.
- 2.1.6. Элсэгчийн дараах бичиг баримтын аль нэгийг ирүүлсэн тохиолдолд хүсэлтийг үндэслэн Англи хэлний түвшин тогтоох шалгалтаас чөлөөлнө. Үүнд:
- Бүрэн дунд боловсролыг Англи хэл дээр эзэмшсэн;
 - Олон улсын их сургуульд Англи хэл дээр Бакалаврын хөтөлбөр эзэмшсэн;
 - Англи хэлний түвшин тогтоох шалгалтад TOEFL (80 iBT-аас доошгүй), эсвэл IELTS (6.0-аас доошгүй) оноо авсан.
- 2.1.7. МГТИС-д элсэхэд дараах тохиолдолд ЭЕШ-ын оноо шаардахгүй:
- Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хүлээн зөвшөөрөгдсөн Байгалийн шинжлэх ухааны чиглэлийн Олон Улсын болон Улсын олимпиадад эхний 5 байр эзэлсэн элсэгч.
 - Боловсрол, шинжлэх ухааны яамны “Оюутан элсүүлэх журам”-д заасан шаардлагыг хангасан элсэгчид.
- 2.1.8. МГТИС-д суралцах чин хүсэл эрмэлзэл, тууштай байдлыг нь дүгнэн тодорхойлох зорилгоор зарим элсэгчээс ярилцлага авч болно.
- 2.1.9. Бакалаврын хөтөлбөрт элсэгчдийн өргөдөл хүлээн авах эцсийн хугацаа нь:
- Дотоодын элсэгчийн хувьд эцсийн хугацааг МГТИС-ийн вэб сайтад байршуулна.
 - Гадаадын элсэгчид 04-р сарын 30 өдрийн дотор бичиг баримтаа ирүүлнэ.
 - Шилжин суралцах оюутнуудын өргөдөл ирүүлэх сүүлийн хугацаа нь намрын улирлын хувьд 05-р сарын 31-ний өдөр хүртэл, хаврын улирлын хувьд 10-р сарын 31-ний өдөр хүртэл байна.

2.2. Магистрын хөтөлбөрт элсэгчдэд

- 2.1.1 Элсэгч нь “Сургалт, шалгалтын ерөнхий журам”-ын дагуу тухайн хөтөлбөрийн бакалаврын дипломтой байна. *(Монгол-Германы Хамтарсан Ашигт малтмал, Технологийн Их Сургууль нь Инженерчлэл болон Байгалийн ухааны чиглэлээр бакалаврын зэрэгтэй элсэгчдийг элсүүлнэ.)*
- 2.1.2 Англи хэлний С1 түвшин (гүнзгий) шаардлагатай. *(энэ журмын 2.1-д дэлгэрэнгүй заасан)*

ACA-PO-001-v4.0-MN-МГТИС-ийн Оюутан элсүүлэх журам

- 2.1.3 Зайлшгүй тохиолдолд тухайн жилийн оюутан элсүүлэх шаардлагыг өөрчлөн зохицуулж болно.
- 2.1.4 МГТИС-д суралцах чин хүсэл эрмэлзэл, тууштай байдлыг нь дүгнэн тодорхойлох зорилгоор зарим элсэгчээс ярилцлага авч болно.
- 2.1.5 Элсэгчийн өргөдөл хүлээн авах эцсийн хугацаа нь тухайн хичээлийн жилийн Намрын улирлын 08-р сарын 15-ны өдөр байна.
- 2.2 Элсэгч нь www.gmit.edu.mn цахим хуудсанд бүртгүүлж, шаардлагатай бичиг баримтыг илгээнэ. Элсэгчид илгээсэн мэдээллийн үнэн зөв болохыг өөрөө хариуцна. Аливаа хуурамч мэдээлэл нь МГТИС-д бүртгүүлсэн тухайн элсэлтийг хүчингүй болгох нөхцөл болно.
- 2.3 Элсэлтийн шаардлагыг хангасан элсэгчдэд МГТИС-иас суралцах эрх олгосон тухай мэдээлэл хүргүүлнэ.

3 Оюутан элсүүлэх

- 3.1 Оюутан элсүүлэх үйл ажиллагааг ЭЕШ дууссан өдрөөс эхлэн ажлын 10 өдөрт багтаан зохион байгуулна.
- 3.2 Шаардлага хангасан элсэгчдэд элсэх эрхийг олгох бөгөөд элсэгч нь МГТИС-д хүсэлтээ баталгаажуулан дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

Бакалаврын хөтөлбөрт

- Бүрэн дунд боловсролын гэрчилгээний эх хувь. Гадаад, эсвэл Монгол дахь олон улсын сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн бол үнэмлэх, гэрчилгээг БШУЯ-аар баталгаажуулсан байна;
- Дотоодын элсэгчид ЭЕШ-ын онооны батламж хуудас, гадаадын элсэгчид ЭЕШ-ын оноог дүйцүүлсэн баримт бичиг;
- Гадаадын элсэгчид англи хэл дээрх элсэхийг хүссэн өргөдөл;
- Англи хэлний түвшнийг тодорхойлох баримт бичиг (*энэ журмын 2.1-д дэлгэрэнгүй заасан*);
- Иргэний үнэмлэхийн хуулбар хувь;
- Сүүлийн гурван сарын дотор авхуулсан цээж зураг 2 хувь;
- Бусад шаардлагатай бичиг баримт.

Магистрын хөтөлбөрт

- Бакалаврын зэргийн диплом болон дүнгийн хуудасны хуулбар хувь;
- Элсэхийг хүссэн өргөдөл (англи хэл дээр);
- Товч танилцуулга буюу CV (англи хэл дээр);
- Англи хэлний түвшнийг тодорхойлох баримт бичиг (*энэ журмын 2.1-д дэлгэрэнгүй заасан*);
- Иргэний үнэмлэхийн хуулбар хувь;
- Сүүлийн гурван сарын дотор авхуулсан цээж зураг 2 хувь;
- Бусад шаардлагатай бичиг баримт.

- 3.3 Элсэх хүсэлт болон холбогдох баримт бичгийг бүрдүүлэн өгөх сүүлийн хугацааг Элсэн суралцах эрх олгосон тухай мэдээлэлд дурдсан байна.

ACA-PO-001-v4.0-MN-МГТИС-ийн Оюутан элсүүлэх журам

- 3.4 Бусад их, дээд сургуулиас шилжин суралцах тохиолдолд сүүлийн байдлаар авсан дүнгийн тодорхойлолтыг 3.2-т заасан баримт бичгийн хамтаар бүрдүүлж ирүүлнэ.
- 3.5 Монгол, Англи хэлнээс бусад хэл дээр бичигдсэн гэрчилгээтэй тохиолдолд баталгаат Англи хэлний орчуулгыг ирүүлнэ.

4. Суралцагчийн гэрээ

- 4.1. Элсэх болзол хангасан элсэгчидтэй Сургалт, оюутны асуудал хариуцсан албанаас “Суралцагчтай байгуулах гэрээ”-г байгуулах ба гэрээнд сургууль болон оюутны эрх, үүрэг, гэрээний тусгай нөхцөлийг тусгасан байна.
- 4.2. Элсэгчид (эсвэл асран хамгаалагчид) суралцах эрх олгосон тухай мэдээлэлд заасан хугацаанд “Суралцагчтай байгуулах гэрээ”-г байгуулна. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан хугацаанд гэрээ байгуулаагүй элсэгчийн элсэх эрхийг хүчингүйд тооцно.
- 4.3. Суралцагч нь гэрээнд гарын үсэг зурснаар МГТИС-ийн оюутан болж, оюутны системд нэвтрэх эрх болон бусад шаардлагатай бичиг баримтыг хүлээн авна.

5. Бусад

- 5.1. Энэхүү “Оюутан элсүүлэх журам” нь 2024 оны 07-р сарын 01-ний өдрийн Захирлын тушаалаар баталгаажсанаар хүчин төгөлдөрт тооцож, дагаж мөрдөнө. Журмын өмнөх хувилбар нь 2024 оны 7-р сарын 02-ны өдрөөс хүчин төгөлдөр бус гэж тооцогдоно. Элсэлтийн хорооны өмнөх шийдвэрүүд нь тухайн үед элссэн оюутанд хэвээр үйлчилнэ.
- 5.2. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад харилцааг Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2024 оны А/143 дугаар тушаалын Хавсралтаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”-аар зохицуулна.